

Монгол улс дахь санхүүгийн салбар дахь шинэчлэлийн ач холбогдол
Илтгэгч: Монгол банкны ерөнхийлөгч Л. Пүрэвдорж

Дэлхийн санхүүгийн хямрал нь 2007 оны дундаас бид бүхэнд хүчтэй мэдрэгдэж эхэлсэн билээ. Үүний үр дүнд дэлхийн хэмжээнд эдийн засгийн үндсэн салбарууд уналтанд орж, ард иргэд хэдэн тэрбум ам.доллараар хэмжигдэх хэмжээний хохирол амсаад байна. Үүнээс болж дэлхийн улс орнууд нийтдээ 4 их наяд ам.долларын хохирол амсана гэсэн Олон улсын валютын сангийн урьдчилсан тооцоо гарчээ.

Ихэнх судлаачдын үзэж байгаагаар уг хямралын анхдагч эхүүсвэр нь АНУ -ын үл хөдлөх хөрөнгийн зээлийн зах зээлээс бий болсон юм. Хямралын өмнө Азийн хурдацтай өгжиж буй улс орнуудаас Америкын эдийн засагт их хэмжээгээр өрөнгө оруулалт хийгдэж байла а. Ийнхүү эх үүсвэр нэмэгдсэнээр тус улсын банк, санхүүгийн байгууллагууд ипотекийн зээлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлсэн байна. Орон сууцны зах зээл асар хурдацтайгаар өсч, томорч байсан учир банкууд үл хөдлөх хөрөнгө, тухайлбал моргейжийн зээлийн нөхцөлийг сулруулж, зээлийн эрсдэлийн удирдлага суларсан. АНУ-д иргэдийн зээл, орлогын харьцаа 2 дахин нэмэгджээ. Мөн зээлийн эрсдэлээ удирдаж, ашиг олох зорилгоор банкууд моргейжийн зээл дээр суурилсан активаар баталгаажсан үнэт цаасыг олноор гаргаж, түүнд хөрөнгө оруулж байв. Энэ нь санхүүгийн салбарыг хэтөндөр хөшүүрэгт оруулсан юм. Орон сууцныгнэ буурсанаар эдгээр санхүүгийн хэрэгслүүдэд хөрөнгө оруулсан банк болон бусад хөрөнгө оруулагчид асар их хэмжээний алдагдал үлээсэн юм . Үүний үр дүнд санхүүгийн системийн хувьд хүчтэй сөрөг нөлөөг үзүүлсэн том банкуудын өлбөрийн чадвараа алдаж, дампуурах үйл явц эхэлсэн юм. Хямрал орон сууцны зах зээлээс өргөжиж бусад эдийн засгийн салбаруудад сөрөг нөлөөг үзүүлж эхэлсэн нь нийгмийн баялагийг хорогдуулж, банкны салбарын чанар зээлийн хэмжээг нэмэгдүүлж, эрсдэл даах чадварыг бууруулсан байна. Зээлийн эрсдэл өссөн нь нэг талаас удаан хугацааны турш үргэлжилж байсан өндөр хөгжилтэй орнуудын эдийн засгийн сааралтын үр дүн байсан болно . Даяаршлагдаж байгаа өнөө үед нэг улсын банк, санхүүгийн байгуулл ага нь бусад улс орнуудтай өрөнгө оруулалт, санхүүжилтаар харилцан нягт холбоотой болсон нь батлагдсан билээ.

Манай улсын хувьд энэхүү хямрал нь АНУ болон бусад өндөр хөгжилтэй улс, орнуудад тохиолдсон шиг орон сууцны зах зээл боловсруулсан системийн хямралаар дамжин нөлөөлөөгүй. Харин Монгол улсын өсвийн орлогын гол хэсгийг бүрдүүлдэг зэсний үнэ дэлхийн зах зээл дээр унаж, хөрөнгө оруулалтын орох урсгал буурсан болно. Ийнхүү бодит салбарт хямралын үр нөлөө хүчтэй туссан нь иргэд, аж ахуйн нэгжийн орлогыг бууруулсан юм. Үүнтэй зэрэгцэн төгрөгийн ханш 2008 оны 4 дүгээр улирлаас 2009 оны 1 дүгээр улирал дуустал хугацаанд огцом суларч гадаад валютаар олгосон зээлийн чанар муудах, банкууд ханшийн тэгшитгэлийн алдагдал хүлээх хүндрэл үүссэн юм. Төгрөгийн ханшийн сулрал нь гадаад валютын зээлтэй иргэдийн хувьд өндөр дарамт учруулсан бөгөөд энэ үед банкны салбарын гадаад валютын чанарыг зээл ийн хэмжээ 2.6 дахин буюу 42 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Энэ үед уул уурхайг түшиглэсэн эдийн засагтай ихэнх орнууд өөрсд ийн үндэсний мөнгөний ханшийг сулруулах бодлого баримтлаж байв. Харин Монголбанкнаас ард түмний нуруун дээр ирэх ханш эрсдэлийн дарамтыг бууруулахаар төгрөгийн ханшийг тогтвортой барих бодлого явуулж байв. Гадаад валютын зах зээл дээр албан болон албан бус захын ханшийн зөрүү огцом өндөр болж, гадаад худалдааны алдагдал өсөхөд нөлөөлсөн байна. Үүний үр дүнд Монгол улсын гадаад валютын албан нөөц 60 гаруй хувиар буурсан юм.

Нийгэмд тархсан банк, санхүүгийн салбарын талаарх сөрөг мэдээлэл, зарим банкны төлбөрийн чадвар муудсан зэрэг нь иргэдийн банкинд итгэх итгэлийг сулруулсан байна. 2008 оны сүүлээр иргэд харилцах, хадгаламжаа татах нь ихэсч харилцах, хадгаламжийн гарах урсгал 2008 оны 10 дугаар сард 123.8 тэрбум төгрөг, 11 дүгээр сард нь 109.3 тэрбум төгрөгт хүрсэн. Үүнийг зогсоохын тулд УИХ-аас Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуулийг 2008 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр батлан гаргасан. Үр дүнд нь хадагаламжийн гадагшлах урсгал аажмаар багасч 2009 оны 6 дугаар сар гэхэд нийт хадгаламжийн хэмжээ хямралын өмнөх үетэй эргэн тэнцэж 2.5 их наяд төгрөг боллоо. Энэ нь банкуудын төлбөрийн чадварт учир ч байсан дарамтыг бууруулсан юм. Өмнө хугацаанд Монголбанкнаас банкуудын хөрвөх чадварыг дэмжих үүднээс банк хоорондын зах зээл дээр урвуу репо, барьцаат зээл, гадаад валютын своп зэрэг хэд хэдэн бүтээгдэхүүнийг бий болгосон.

Эдийн засгийн өсөлт саарч, бодит салбарын үйл ажиллагаа зогсонги байдалд орсоноос зээлдэгчдийн өлбөрийн чадвар буурч зээлийн эрсдэл өслөө. Иймээс банкуудын зээлийн багцын чанар хурдацтай муудаж байна. Жишээлбэл, эхний хагас жилийн байдлаар уул уурхайн салбарын чанаргүй зээл тухайн салбарын нийт зээлийн 19.9%, барилгын салбарынх 17.3%, боловсруулах үйлдвэрлэлийнх 11.7%, худалдааных 10.9% хүртэл өсчээ. Нийт банкны салбарын зээлийн багцын өвлөрсөн салбаруудад эрсдэл өссөнөөр чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувийн жин 13.4 нэгжээр нэмэгдэж 15.2 хувьд хүрчсэн. Улсын хэмжээгээр зээлийн эрсдэлийн ерөнхий түвшин өссөнөөр банкууд зээл олголтыг бууруулж, зээлийн нөхцөлийг хатууруулах, өмнө олгосон байсан зээлийн эргэн төлөлт дээр анхаарч ажиллахад хүргэж байв.

Америк болон бусад ихүрнүүд хямралтыг гэтлэн туулахаар хамтран ажиллаж, зах зээлийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, эдийн засгийг өсөлтийг хангах бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Энэ хүрээнд төлбөрийн чадвараа алдсан болон системийн хувьд ач холбогдолтой банкууд, улсын нийт баялагийг үгтээлцдэг тэргүүний корпорациудад санхүүжилт олгох, санхүүгийн салбараас чанаргүй активыг арилгах арга хэмжээнүүд багтсан юм. Үүний дараа энэ оны 1 дүгээр улирлаас хойш олон улсын эдийн засаг, санхүүгийн зах зээлд зарим нааштай өөрчлөлтүүд ажиглагдлаа. Өндөр хөгжилтэй орнуудад банкууд банк хоорондын захаас богино хугацааны хөрвөх чадвараа хангах хангалттай хэмжээний эхүүсвэр татах боломжтой болсон байна. Мөн үүсмэл үнэт цаасны зах зээл эргээд сэргэх хандлагатай болжээ. Монголбанкны хувьд банкуудын өрийн хөрөнгийн зохистой харьцааны шалгуурууд үзүүлэлти йг 12 хувь болгон нэмэгдүүлэн тогтоож, банкуудад үзүүлэх эрсдэлийн сангийн дарамтыг бууруулахаар активын ангилалын журамд Сангий сайдтай хамтран өөрчлөлт оруулсан юм. 2009 оны 3 дугаар улирлаас Монгол улсын гадаад худалдааны алдагдал буурч байгаа явдал болон Монголбанк гадаад валютын арилжааны дуудлага худалдааг нэвтрүүлсэнээр төгрөгийн ханшийг тогвортой бариж байна. Харьцангуй зогсонги байдалд байсан банкуудын зээл олголтын үйл ажиллагаа сэргэх дүр зураг ажиглагдаж байна.

Хамгийн гол нь хямралаар дэлхий улс орнууд урьд өмнө нь банк, санхүүгийн харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн актуудад байсан олон алдаа зөрчлийг

илрүүлсэнд эерэг тал оршино. Монгол улсын хувьд долларжихүйл явцтай тэмцэж, өгрөгийн ханшийн тогвортой байдлыг хамгаалах хэрэгтэйг өнгөрсөн туршлага харуулсан. Бид банкуудынүйл ажиллагааны эрсдэлийн удирдлаыг сайжруулахаар олон улсын тэрүний туршлагыг Монголд нэтрүүлэхээр судлаж байна. Мөн санхүүгийн зах зээлд гарч байгаа зарим гол эерэг үзүүлэлтэд сэтгэл амрах биш цаашид банкны салбарын хяналт шалгалтыг сайжруулах, олон улсынүртбл, хяналт шалгалтын стандартуудыг нэвтрүүлэх зэрэг олон ажлыг хийх хэрэгтэй юм. Монголбанк, Сангийн яам, Монгол улсын засгийн газар экспортыг дэмжих бодлогыг тууштай хэрэгжүүлж, ялангуяа үндэсний үйлдвэрлэлийг бодлогоор анхаарах нь зүйтэй.